

БАТЛАВ
САНГИЙН САЙД



З.МЭНДСАЙХАН

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД



Ж.ЭНХБАЯР

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД




Э.БАТШУГАР

БАТЛАВ
БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД



Д.БАТЛУТ

БАТЛАВ
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД



Ж.АЛДАРЖАВХЛАН

БАТЛАВ
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД



Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД



С.АМАРСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 19-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН “САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ

Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл, 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 134 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Монгол Улс Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт Бүгд Найрамдах Австри Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Вольф Дитрих Хейм болон Сангийн сайд З.Мэндсайхан нар 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

Тус Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улс Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Бүгд Найрамдах Австри Улсын эх үүсвэрээр “Хорт хавдрын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл”, “Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулах”, “Монгол Улсад эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл”, “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн III шатны төсөл”, “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ба хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах дараагийн шатны төсөл”, “Дуурь бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой болно.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.

oOo